

Аймгийн Засаг даргын 2013 оны дугаар
сарын –ны өдрийн дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

ЗАЛУУ МАЛЧДЫГ МАЛЖУУЛАХ САНГИЙН ХӨРӨНГИЙГ ЗАХИРАН ЗАРЦУУЛАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ

Нэг: Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Залуу малчдыг малжуулах” сангийн хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Залуу малчдыг малжуулах сан /цаашид “сан” гэх/ төрийн санд тусгай данстай байх бөгөөд сангийн орлого, зарлагыг энэхүү дансаар дамжуулан гүйцэтгэнэ,

1.3. Сан нь төрийн сангаас гадуур данстай байхыг хориглоно,

1.4. Сангийн орлого, зарлага нь сумын төсвийн гүйцэтгэлийн улирал жилийн тайлан тэнцэлд тусгагдана,

1.5. Сангийн хөрөнгө нь залуу малчдыг малжуулах, ингэснээр шинээр ажлын байр бий болгох, залуу малчдыг дэмжихэд зориулагдана,

1.6. Сангийн хөрөнгийг сумын төсвийн алдагдал нөхөх, төсөвт байгууллагын үйл ажиллагааг санхүүжүүлэх, 1.5-д зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно.

Хоёр: Сангийн хөрөнгийн эх үүсвэр

2.1. Сангийн хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ,

2.1.1. Улсын төсвөөс олгох залуу малчдыг малжуулах сангийн хөрөнгө,

2.1.2. Гадаад улс, олон улсын байгууллагын буцалтгүй тусламж хандив,

2.1.3. Гадаад, дотоодын аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс өгсөн буцалтгүй тусламж хандив,

2.1.4. Орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс өгсөн буцалтгүй тусламж хандив.

Гурав: Сангийн удирдлага зохион байгуулалт

3.1. Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал сангийн хөрөнгөөс залуу малчдыг малжуулах, хяналт тавих талаар дараах эрх үүргийг гүйцэтгэнэ,

3.1.2. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтанд хяналт тавих чиг үүрэг бүхий 5 хүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус зөвлөлийг /сангийн зөвлөл/ сумын

иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчөөр ахлуулан байгуулна. Зөвлөлийг байгуулахдаа иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол гаргана.

3.1.3. Сангийн зөвлөл “Санд” хамруулах малчдыг багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлж иргэдийн саналыг үндэслэн тогтооно,

3.1.4. Сумын ИТХурал нь тухайн сангаас жилд нэг малчинд олгох /мал/ мөнгөний хэмжээ, санд тогтоож эргэн төлөгдөх хугацааг тогтоож өгнө,

3.1.5. Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэн, иргэдэд мэдээлэх,

3.1.6. Багийн иргэдийн нийтийн хурлаар санд хамрагдахаар сонгон шалгарсан залуу малчдын материалыг Засаг даргад өргөн барина,

3.2. Сумын Засаг дарга сангийн үйл ажиллагаатай холбогдсон дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ,

3.2.1. Багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлж санд хамрагдахаар сонгон шалгарсан залуу малчдын материалыг үндэслэн /мал/ зээл олгох шийдвэр гаргана,

3.2.2. Санд хамрагдахаар сонгон шалгарсан малчинтай гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг хангуулах хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавьж ажиллана,

3.2.3. Сангийн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийн дагуу хөтлүүлж, санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг гаргаж сумын иргэдийн төлөөлөгчдийн хуралд тайлагнах,

3.2.4. Сангийн үйл ажиллагааны үр дүнг сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын өмнө хариуцана,

3.2.5. Сангийн хөрөнгийн зарцуулалт, бүрдүүлэлттэй холбоотой мэдээллийг жил бүрийн 6 дугаар сарын 10-ны дотор Хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрийн газар, Санхүү төрийн сангийн хэлтэст ирүүлнэ.

Дөрөв: Залуу малчдыг малжуулах санд хамрагдах малчинд тавигдах шаардлага

4.1.1 Малчин нь тухайн суманд бүртгэлтэй, байнгын оршин суугч байх,

4.1.2 Сум хөгжүүлэх сан болон жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урьд авсан зээлийн хугацаа хэтрээгүй байх,

4.1.3 Мал маллах сонирхолтой, мал аж ахуйн анхан шатны мэдлэгтэй байх,

4.1.4 Жилийн дөрвөн улиралд мал аж ахуйд ажиллах боломжтой байх

4.1.5. Малчин мэргэжлийн үнэмлэхтэй байх

Тав. Сангийн үйл ажиллагааг тайлагнах

5.1.1 Сангийн үйл ажиллагааг нийтэд ил тод явуулна. Сангийн хөрөнгийн зарцуулалт ашиглалт тайлагналтад тухайн сумын иргэд хяналт тавих эрхтэй,

шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн хяналт шалгалт хийлгүүлж болно,

5.1.2 Сангийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах үүргийг сумын засаг дарга хариуцна,

5.1.3 Энэхүү журмын 3.1.2-д заасан ажлын хэсэг сангийн үйл ажиллагааны хэрэгжилт явц байдалд тухайн санхүүгийн жилд 2-оос доошгүй удаа шалгалт хийж дүнг Иргэдийн Төлөөлөгчийн болон Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж, сумын нийт иргэдэд мэдээлж байна,

5.1.4 Сангийн зөвлөл нь жил бүрийн малжуулах сангийн гүйцэтгэл үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит хийлгэж, аудитын дүгнэлтийг сумын ИТХ-аар хэлэлцүүлж, нэгдсэн дүнг Төрийн сан, эдийн засгийн хэлтэс, ХХААЖДҮ-ийн газарт хүргүүлэх ажлыг зөвлөл хариуцаж ажиллана.

Зургаа. Батлан даагчийн хүлээх үүрэг

6.1.1. Батлан даагч нь зээлдэгчийг үүргээ биелүүлэхгүй тохиолдолд уг төлбөр тооцоог өөрөө хариуцан гүйцэтгэхээр үүрэг хүлээсэн байна.

6.1.2. Батлан даагч нь өөрийн өмчинд 300 гаас дээш толгой малтай байх бөгөөд мал аж ахуйн салбарт 10 –ээс дээш жил ажилласан туршлагатай байна.

6.1.3. Батлан даагч нь батлан даалгуулагчийн гэрээний хугацаа дуусмагц, батлан даалтын төлбөрийг бүрэн хийнэ

6.1.4. “Аймгийн сайн малчин”, “Улсын сайн малчин”-д шалгаруулахад 2 доошгүй малчинг малжуулж, батлан даасан байна.

Долоо. Хариуцлагын тогтолцоо

7.1.1 Сангийн хөрөнгийг зарцуулах ашиглах хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааны талаар энэхүү журмаар тогтоосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хуульд заасан хариуцлагыг хүлээлгэнэ,

7.1.2 Малжуулах санд хамрагдсан хариуцагч этгээд /мал/ авсан зээлээ үр ашиггүй зарцуулсан эсхүл зээлийг гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулаагүй бол сангаас олгосон хөрөнгийг буцааж төлүүлэх, бусад дэмжлэг туслалцаа арга хэмжээнд дахин хамруулахгүй.

7.1.3 Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй хяналт тавиагүй нь эрх бүхий этгээдийн хяналт шалгалтаар тогтоогдсон бол сумын Засаг даргад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Малжуулах сангаас олгох зээлийн
гэрээний үлгэрчилсэн загвар

2013 он сар өдөр

Дугаар.....

Нэг: Ерөнхий зүйл

1.1. Энэхүү гэрээгээр улсын төсөв болон журамд заасан санхүүгийн эх үүсгэвэрээр залуу малчдыг малжуулах санд хамрагдахаар шалгарсан малчинд зээл олгохтой холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Нэг талаас аймгийн сумын Засаг дарга овогтой нөгөө талаас аймгийн сумын малчин овогтой нар дор дурдсан нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Хоёр: Гэрээний хугацаа

Энэхүү гэрээ 2013 оны дугаар сарын өдрөөс оны сарын өдрийг хүртэл хүчинтэй.

Гурав: Малчны эрх үүрэг

3.1. Сангаас олгох /мал/ төгрөгийн хөрөнгө оруулалтыг залуу малчныг малжуулах сангийн журмын дагуу зориулалтаар зарцуулна,

3.2. Сангаас олгосон /мал/ төгрөгийг гэрээнд заасан хугацаанд малжуулах санд эргүүлж төлнө,

3.3. Энэхүү гэрээний хугацаанд сангаас олгосон зээлээ малжуулах санд төлөөгүй тохиолдолд мөнгөн дүнгээр нь бодож сарын хувийн торгууль төлнө.

Дөрөв: Засаг даргын эрх үүрэг

4.1. Залуу малчдыг малжуулах сангаас /мал/ төгрөгийг оны сарын –ны дотор сонгон шалгарсан малчинд олгоно.

4.2. Сангаас авсан /мал/ төгрөгийг гэрээнд заасан хугацаанд малжуулах санд шилжүүлээгүй бол үл маргах журмаар төлүүлэх, шаардлагатай бусад арга хэмжээ авна,

4.3. Сангаас өгч байгаа малд нас, хүйс, тараг хүч үржилд тэнцэх эсэхэд хяналт тавьж малыг олгоно,

4.4. Гэрээний үүргийн биелэлтийг хангуулах, үйл ажиллагаа, эргэн төлөлтөнд хяналт тавина,

4.5. Санд хамрагдсан малчны үйл ажиллагаа хэрэгжилтийн явц байдалтай танилцана.

Тав: Маргааныг шийдвэрлэх

5.1. Энэхүү гэрээ талуу гарын үсэг зурж баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно,

5.2. Гэрээнд оруулах нэмэлт өөрчлөлтийг оролцогч талуу харилцан зөвшөөрснөөр шийдвэрлэнэ,

5.3. Энэхүү гэрээтэй холбоотой аливаа маргаантай асуудлыг хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд шийдвэрлэх боломжгүй бол асуудлыг Шүүхээр шийдвэрлүүлнэ.

Зургаа: Бусад зүйл

6.1. Энэ гэрээг адил хүчинтэй гурван эх хувь үйлдэж нотариатаар баталгаажуулж, талууд хадгална.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Зээлдүүлэгч

Зээлдэгч

.....СУМЫН ЗАСАГ ДАРГА
...../...../

.....СУМЫНБАГИЙН
МАЛЧИН/...../

Батлан даагч

.....Батлан даагч малчин
...../...../

№	Малжуулах сангийн хөрөнгө тусгагдсан байдал	Сая төгрөг
1	Дөргөн	60.0
2	Буюнт	60.0
3	Алтай	150.0
4	Дарви	45.0
5	Зэрэг	50,0
6	Манхан	50,0
7	Мянгад	40,0
8	Мөст	50,0
9	Эрдэнэбүрэн	40,0
10	Чандмань	40,0
11	Мөнххайрхан	50,0
12	Ховд	50,0
13	Цэцэг	50,0
14	Үенч	50,0
15	Дуут	50,0
16	Булган	80,0
	нийт	915,5